



Хэвлэлийн мэдээ
2022.03.10

Холбоо барих
+976 99013322

**АмЧам Монголы хэлэлцүүлгийн үр дүнд Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилттэй
холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр боллоо**



УЛААНБААТАР, Монгол Улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2022 оны 3-р сарын 10-нд “Монгол Улсын нийгмийн хамгааллын шинэчлэл ба хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэг амжилттай зохион байгууллаа. Хүндэт илтгэгчээр Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А. Ариунзаяа мөн Ард Санхүүгийн Нэгдлийн Ард Лайф-ийн Захирал Б.Гантулга оролцлоо. Энэхүү уулзалтад АмЧам Монголын гишүүд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон Монголд үйл ажиллагаа явуулдаг элчин сайдын яамдын төлөөлөл зэрэг 90 гаруй зочид төлөөлөгчид оролцов. 2022 оноос хэрэгжиж эхэлсэн хуулийг 1999 оны Хөдөлмөрийн хуультай харьцуулахад хамрах хүрээ өргөжиж, олон дэвшилтэй үзэл санаа, заалтууд тусгасан бөгөөд цаашид энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд зарим

тодруулах зүйлүүд байгаа. Тухайлбал, ажил олгогчдод санхүүгийн нэмэлт дарамт үүсэх, ажиллагсдын орлого буурахад хүрч байна.



Мөн зарим хуулийн заалтыг бодитоор хэрэгжүүлэхэд тодорхой бус байдалтай байгаа бөгөөд хуулийг дагалдан гарах журмуудад ажил олгогчдын саналыг тусгах шаардлагатай байна.

Нөгөө талаас Монгол Улсын тэтгэврийн шинэчлэлийг зоригтой бөгөөд цогцоор нь хийх нь өрсөлдөх чадвартай, сонголттой, тэтгэврийн тогтолцоог бий болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, улмаар тэтгэвэрт гарагчдын амьжиргаа дээшлэх ач холбогдолтой байх билээ.

А. Ариунзаяа сайд хэлэхдээ, Хөдөлмөрийн тухай хууль нь таван Засгийн газар, гурван парламент дамжиж 1995 оноос хойш анхны шинэчилсэн найруулгаар гарч үүнд 30-40 удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан түүхтэй. Мэдээж шүүмж байна, магтаалууд ч байна. Нэг талаасаа ажил олгогчдод

илүү ачаалал үүрүүлсэн хүнд хууль боллоо гэж харж байгаа, нөгөө талаасаа ажилчдын эрх ашгийг хамгаалсан сайн хууль гэж харж байгаа. Ажил олгогч хэзээд давуу талтай байдаг, тэгэхээр ажилчдын эрх ашгийг хамгаалах нь хуулийн үндсэн үүрэг мөнөөс мөн. Ажил олгогчдын холбоо, танхим нөгөө талаас үйлдвэрчдийн эвлэл хамтдаа олон удаа хэлэлцүүлэг, мэтгэлцээнүүд хийж байж дундын хүлээн зөвшөөрсөн зааг дээр зөвшөөрөгдсөн. Эмэгтэй хүний хувьд жендерийн чухал асуудлуудыг хөндөж оруулсанд би их баярлаж байгаа бөгөөд ялангуяа хүүхдийг зөвхөн эмэгтэй хүн хардаггүй шүү гэдэг ойлголтыг шингээж өгсөн, түүнчлэн албан ёсны шинэ хүүхэдтэй болсон аавын цалинтай чөлөөний тухай заалт орсон, үүгээр дамжуулан хүүхдийн хамгааллын бодлого мөн явж байгаа.

Магадгүй өнөөдрийн ойлгомжгүй байгаад байгаа асуудлуудын нэг бол уул уурхайн салбарын уртын ээлж буюу ростерын асуудал. Анх өргөн барьсан хуулинд хатуу 14:14 гэсэн заалт байгаагүй, гэхдээ хэлэлцүүлгийн явцад уурхайчдын үйлдвэрийн эвлэлийн зүгээс гэр бүл, үр хүүхдэд зав цаг гаргах хэрэгтэй байна цалин хэдийгээр багасахыг ойлгож байгаа гэсэн хариулт өгч энэ заалтыг оруулж байсан. Одоо гар дээрх цалин нь багасахаар уурхайчид дургүйцэж эхэлж байна, нөгөө талаасаа ажил олгогчид шинэ ажлын байр гаргах шаардлагатай болсон. Энэ дээр тухайн ААН өөрсдөө зохицуулалт хийсэн олон жишээ мөн бий. Аливаа асуудал ямар ч эрсдэлгүй байна гэж байхгүй, алдаа байвал мэдээж хэлэлцэж засахын төлөө ажиллана.

Тэтгэврийн шинэчлэлийн хувьд Улсын Их Хурал дээр хуулийн төсөл өргөн баригдсан байгаа. Тэтгэврийн тогтолцоо дэлхий дээр 2-р тогтолцоо л байдаг: хуваарилалтын ба хуримтлалын тогтолцоо. Тэтгэврийн тогтолцоо нь улс төрөөс хамааралтай байсан нь одоогийн алдаа дутагдалд нөлөөлсөн. Нэг талдаа ард иргэддээ ээлтэй бодлогууд байсан хэдий нөгөө талаасаа популист амлалтууд хийж сангийн алдагдал нэмсэн. Иргэн нийгмийн даатгалын үр шимийг мэдээгүйгээс болж төлөөгүй, хамрагдаж чадаагүйгээс болж нөхөн төлөх боломжууд гаргаж байсан. Иргэд нийгмийн даатгалыг татвар юм шиг ярьдаг, зөвхөн өндөр насны тэтгэвэр авдаг гэж андуурдаг. Уул нь дотроо дөрвөн сантай, үр шимээ өгч байгаа олон тэтгэмжүүд байгаа энэ тогтолцоогоо аль болох олон хүнд хүргэх, мөн олон улсад байгаа сайн жишээнүүдийг нэвтрүүлэх хэрэгтэй.

Уулзалтын үеэр Ард Лайф-ийн Захирал Б.Гантулга “Монгол улсын тэтгэврийн тогтолцооны шинэчлэл, реформ” сэдвээр илтгэл тавьсан бөгөөд Монгол улс аажмаар тэтгэврийн даатгалын сан болон сайн дурын хувийн тэтгэврийн сангууд дээр үндэслэсэн 3 тулгуурт тэтгэврийн тогтолцоонд шилжих шаардлагатайг онцлов. Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны мэдээгээр албан журмын даатгалд 1 сая хүн, сайн дурын даатгалд 160.000 гаруй хүн, 52.000 ААН хамрагдаад явж байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны байдлаар 2,7 их наяд төгрөг байгаа, сангаас 750.000 хүнд тэтгэвэр тэтгэмж олгосон байгаа энэ нь 2,5 их

наяд төгрөг олгосон. Тэтгэврийн хэмжээ 2012 онтой харьцуулахад 3.5% нэмэгдсэн, 2020 оны байдлаар дундаж тэтгэвэр 420.000 төгрөг байсан өнөөдөр дундаж тэтгэвэр 540.000 төгрөгт хүрч нэмэгдсэн.

Б.Гантулга үргэлжлүүлэн хэлэхдээ, “Тэтгэврийн даатгалын сан сүүлийн 10 жил дараалан алдагдалтай ажиллаж, 2022 онд 1.2 их наяд төгрөгийн алдагдал үүсгэж байна. Тэтгэврийн хэмжээ нэмэх нь сангийн зарлагын хэмжээг нэмнэ. Нөгөө талд орлого нэмэгдүүлэх оролдлого олон нийтийн дунд асар их бухимдал, эсэргүүцэлтэй тулгарч байгаа. Зарлага багасгах зорилготой тэтгэврийн нас нэмэгдүүлэх нь иргэн болон байгууллагад эрсдэлтэй, хэцүү мөн олон нийтийн дунд асар их бухимдалтай тулгарч байна. Бид эхний ээлжид яаралтай хувийн тэтгэвэр-ийн сангийн тогтолцоог зохицуулсан хууль эрх хүйн орчныг бүрдүүлж сайн дурын үндсэн дээр иргэд тэтгэвэр-ийн хуримтлал үүсгээд явах боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Компани, байгууллага албан журмаар тэтгэвэр ийн даатгалын шимтгэл шууд тэтгэврийн даатгалын сан (ТДС)-д төлж байгааг болиулж ТДС болон хувийн тэтгэврийн сан (ХТС)-аас компани байгууллагууд сонгодог болгох, ингэхдээ шат дараалалтайгаар 2%-иар 4 жилийн хугацаатай шилжилтийг явуулж компани, байгууллагууд өөрсдөө сонгодог болох хэрэгтэй” гэв.



Уулзалтын төгсгөлд хүндэт илтгэгчид дундаж цалин хөлс тодорхойлох журам, хувийн тэтгэврийн сан, зохицуулалт болон бусад олон асуултад дэлгэрэнгүй хариулт өгсөн бөгөөд тухайлбал өнгөрсөн онд баталсан дундаж цалин хөлс тодорхойлох журмын дагуу нэмэгдэл хөлсийг дундаж цалин хөлс дээр үндэслэн тооцохоор байгаа нь ажил олгогчдын цалингийн зардлыг үндэслэлгүйгээр хэт их өсгөж байгаа тухай АмЧам Монголын гишүүдээс ирсэн санал шүүмжлэлийг А.Ариунзаяа сайд хүлээн авч, энэхүү журмыг дахин нягталж, шаардлагатай өөрчлөлтийг яаралтай оруулна гэж хэлэв.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.